



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

154

дохи оны 10 сарын 06 өдөр

Дугаар 241

Мандалговь

Г

Хөрөнгө худалдах тухай


Г

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.д, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14'600'000 /арван дөрвөн сая зургаан зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 608'000 /зургаан зуун найман мянга/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 00-66 дуа улсын дугаартай УАЗ-22069-033 маркын пургон автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 1'500'000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга Л.Гүндсүрэнд даалгасугай.



0100524